

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ  
(С.БАЯРЫН ЗАСГИЙН ГАЗАР 2 ДАХЬ 100 ХОНОГ)

Улаанбаатар хот  
2009 он

## ЗАСГИЙН ГАЗРЫН 2009 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлээд хоёр улирал өнгөрч байгаа бөгөөд 2009 оны нэгдүгээр улиралд улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх нэн тэргүүний бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлүүлэх талаар эрчимтэй ажиллалаа.

Юуны өмнө “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Засгийн газрын 2009 оны 1 дүгээр тогтоолоор, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г мөн оны 2 дугаар тогтоолоор тус тус батлан хэрэгжүүлж эхэллээ.

### **Нийгмийн хамгааллын талаар**

Нийгмийн эмзэг бүлгийг дэмжих чиглэлээр: **2008 оны сүүлээс дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал манай улсад нөлөөлж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газар нийгмийн хамгааллын бодлого, үйл ажиллагаагаа нийгмийн эмзэг бүлгүүдэд чиглүүлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тэдгээрийг хямралын нөлөөнд өртүүлэхгүй байх, нийгмийн хамгаалал, халамжийн тусламж, үйлчилгээг зорилтот бүлгүүдэд хүргэн ажиллаж байна.**

Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулахад нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай, Эх хүүхдэд, тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэтгэмжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай зэрэг хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

**Бага орлоготой, ядуу өрхийг хямралын сөрөг үр дагавраас сэргийлэх, амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээг авах, ажлын байр хадгалах, шинээр ажлын байр бий болгох, нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах тухай журам, өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг шинэчлэн боловсруулж мөрдөхөөр ажиллаж байна.**

“Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хүүхэд бүрт олгож буй хүүхдийн хөгжлийн мөнгийг өөрчлөх тухай” болон “Шинээр гэрлэгсдэд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөх тухай” тогтоолын төслийг УИХ-д өргөн барив.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг бүтэн өнчин хүүхэд, нэн ядуу өрхийн хүүхэд, олон хүүхэдтэй ядуу болон дундаж амьдралтай өрхийн хүүхэд болон эцэг эх нь удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих ял эдэлж байгаа өрхийн хүүхдүүд, хараа хяналтгүй болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд чиглүүлэх талаар эхний тооцоо, судалгааг хийж байна.

**Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулж ахмад дайчдад улиралд нэг удаа олгох мөнгөн тусламжийг сар бүр 200.000 төгрөг болгон 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр байна.**

**“Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц, эсхүл түүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн тусламж олгох журам”-ын дагуу орон сууц, мөнгөн тусламжид хамрагдах 1939 оны Халх голын дайнд оролцсон ахмад дайчдын нэрсийн жагсаалтыг гарган баталж, тэдэнд орон сууц, мөнгөн тусламжийг олгоод байна.**

**Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди сар шинийн өмнө хоёр дайнд оролцож явсан ахмад дайчин Ж.Лувсандэндэв, Д.Батаа, С.Борхүү нарт орон сууцны түлхүүр болон мөнгөн тусламж гардууллаа. Энэ удаагийн арга хэмжээнд хоёр дайнд оролцож явсан 44 ахмад дайчинд орон сууц, мөнгөн тусламж олголоо. 2009 онд нийт 90 гаруй ахмад дайчны орон сууцны асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөж байна.**

Төрийн албаны тухай хуулийн 24.1, 24.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын төсөл боловсруулав. Төсөлд төрийн жинхэнэ албанд тогтвор суурьшилтай ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн албан хаагчид 36 хүртэл сарын нэг удаагийн буцалтгүй тусламжийг төрийн алба хаасан хугацаанаас хамааруулан 12-36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээгээр олгоход энэ журмыг мөрдөх юм.

Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг түр хоноглох байранд байрлуулж, өдөрт нэг удаа халуун хоолоор үйлчлэх АХБ-ны 3.3 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаар хөтөлбөр хэрэгжүүлэхээр орон нутагт судалгаа хийж байна.

Тэнэмэл амьдралтай гудамж, орц траншейгээр байнга тэнүүчлэн амьдардаг 50 гаруй хүүхдийг дулаан орон байранд өвөлжүүлэх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулан зохих эмчилгээ, сувилгаа хийх, бичиг баримтжуулах, нийгэмшүүлэх, сэтгэл засал, амьдралын итгэл үнэмшил олгох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулав.

“Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийн нэг зорилт болох хүн амын төвлөрөл ихтэй, орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэд олноор суурьшиж буй Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад “Түр хоноглох байр, халуун хоол үйлчилгээг зохион байгуулах арга зүй, хэрэгцээ шаардлага” сэдэвт хэлэлцүүлгийг Хүнсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих нэгж, Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран зохион байгуулав. Тус хөтөлбөрийн хүрээнд ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулан **талон** тараах бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 37000 хүний нэрсийг ирүүлснийг баталгаажуулах ажлыг эхлүүлээд байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Ядуурлын зураглалыг анх удаа хийж, танилцуулах уулзалтыг зохион байгуулж TV-9, SBN, C1, ТМ, Өглөөний сонин, Монголын мэдээ, МОНЦАМЭ мэдээ, Нийгмийн толь, Ардчилал, Үнэн, Зууны мэдээ сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл хийв.

**Нийгмийн хамгаалал, халамжийг зорилтот бүлгүүдэд чиглүүлэн хэрэгжүүлснээр тэднийг санхүү, эдийн засгийн хямралын нөлөөлөлд өртөх эрсдэлийг бууруулж, амьжиргааг баталгаатай болгож байна.**

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: **Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг улс орны эдийн засгийн тэргүүлэх салбаруудад шаардлагатай байгаа мэргэжилтэй ажилтан бэлтгэх замаар хөдөлмөрийн идэвхтэй насны хүн амыг хамруулан хэрэгжүүлж, дотоодын ажиллах хүчний нөөцөд тулгуурлан томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлж байна.**

Уул уурхай, зам, барилгын салбарт нэвтэрч буй шинэ техник, технологийг ашиглан тэнд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, мэргэжил, ур чадварыг нь тасралтгүй хөгжүүлэх замаар ажил олгогч болон ажилчдын тогтвортой хамтын ажиллагаа, түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэл, сургалтын дэд хөтөлбөрийг батлав. Түүнчлэн уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Мянганы сорилын сангийн Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын төслөөс дэмжлэг авах талаар санал тавьж, үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах багш, сургагч нарыг бэлтгэх, сургалтын хөтөлбөр, модуль боловсруулах, сургалтын эрэлт, хэрэгцээгээ тодорхойлох зэрэг чиглэлээр дэмжлэг авахаар тохиролцов.

Эдийн засгийн хямралын үед ажлын байрыг хадгалахад эзэд, хөдөлмөрчдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон хамгаалах чиглэлээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, МҮЭ-ийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо хамтран хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон санамж бичигт гарын үсэг зурав. Энэ ажлын хүрээнд уул уурхай, зам, барилгын салбарт шаардах ажлын байрны талаар танилцах сургалтыг зохион байгуулснаар 3600 гаруй иргэнийг үйлдвэрлэл дээрх сургалтад хамруулах, ажлын байраар хангах, сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийн сангаас гаргахаар шийдвэрлээд байна.

“Хямралын үеийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого” сэдэвт уулзалт, ОУХБ, БНСУ-ын Түншлэлийн хөтөлбөр, ОУХБ, Европын Холбооны “Хөдөлмөрийн гадаад шилжих хөдөлгөөний удирдлага”, Азийн хөтөлбөрийн хүрээнд “Солонгосын гадаадаас ажилчин авах систем ба хоёр талын хамтын ажиллагаа” сургалт семинарыг зохион байгуулав. Уг сургалтаар НХХЯ, БНСУ-ын Хөдөлмөрийн яамны хооронд байгуулсан “БНСУ-д ажилчид илгээх тухай” Санамж бичгийн хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцож, зөвлөлдөв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн баталж, Салбар зөвлөлийг Засгийн газар, ажил олгогч, ажилчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав.

НҮБ-ын Хүүхдийн сан болон Олон улсын шилжин суурьшлын байгууллага, Нийгмийн ажлын багш сурагчдын холбоотой хамтран нийслэлийн бүх дүүрэг, Ховд, Дорнод аймагт хүүхэд хамгаалал, түүний дотор хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, дамжуулан худалдаалахтай тэмцэх асуудлаар нийгмийн ажилтныг чадавхижуулах сургалтыг зохион байгуулав.

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх Үндэсний зохицуулах хороо, ажлын албаны бүрэлдэхүүн, хорооны ажлын удирдамжийг шинэчлэн баталж, Хорооны бүрэлдэхүүнийг салбарын 7 яам, 3 агентлаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, 2 ТББ, ажил олгогч, үйлдвэрчний байгууллагын төлөөлөлтэй байгуулав.

БНАСАУ-тай Ажиллах хүчин харилцан солилцох хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар төслүүдийг солилцов.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлж мэргэжилтэй ажилтан бэлтгэх гол бааз болсон Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын орчныг сайжруулснаар тэдгээрт суралцагчдын тоо нэмэгдэж, томоохон төслүүдэд ажиллах ажилтнууд бэлтгэгдэж байна.

### **Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлж эхлэн бүх шатны боловсролыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, гадаадын өндөр хөгжилтэй орнуудын их сургуулиудад нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр анхааран ажиллаж байна.

Ерөнхий сайдын Люксембургийн Их Гүнт Улсад хийсэн айлчлалын үеэр Монгол Улс, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хоорондын Соёлын хэлэлцээрийг байгуулав.

Мөн Монгол Улсын БСШУЯ, ОХУ-ын Соёлын яам хоорондын 2009-2011 онд хамтран ажиллах хөтөлбөрт гарын үсэг зурж, Оросын соёлын өдрүүдийг Монголд зохион байгуулах тухай яам хоорондын Протоколын төслийг боловсруулан Оросын талд хүргүүлээ.

Японы Олон Улсын хамтын ажиллагааны төвтэй хамтран “Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх талаар 2009 онд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулав.

Япон Улсын Засгийн газартай 2006, 2007 оны төсөвт дэмжлэг үзүүлэх хуримтлалын санд эргэн төвлөрсөн 8.0 сая ам. долларын орлогыг төслийн бус буцалтгүй тусламжийн хэлбэрээр 2009 онд ашиглан санал болгосон төслүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, холбогдох талуудтай хамтран ажиллав.

**Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол: Ерөнхий боловсролыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр анхааран ажиллалаа.**

Европын Холбооны Комисс, Их Британийн Хүүхдийг ивээх сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах нь” төслийн хүрээнд “Хүүхдэд ээлтэй сургуулийн өмнөх боловсрол” үндэсний чуулганыг зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж буй 100 гаруй төлөөлөгчийг оролцууллаа.

Спортын төв ордны материаллаг баазыг түшиглэн байгуулсан спортын сургалттай дунд сургуулийг албан ёсоор нээлээ. Уг сургуулиар дамжуулан эрүүл чийрэг бие бялдартай иргэдийг өсгөх, биеийн тамир, спортын чиглэлээр хичээллэгчдийн авъяас, чадварыг тусгай хөтөлбөрийн дагуу хөгжүүлэх үндэс суурь тавигдаж байна. Сургуульд жудо бөх, бокс, чөлөөт бөх, буудлага, спортын болон уран сайхны гимнастик, хөнгөн атлетик, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг, цана, тэшүүр, ширээн теннис, шатар, даам зэрэг спортын 15 төрлөөр дунд ангиас нь эхлэн тодорхой шалгуурын дагуу сурагчдыг элсүүлэн авч байгаа бөгөөд одоо 200-аад хүүхэдтэйгээр хичээллэж байна.

**2008-2009 оны хичээлийн жилд аймаг, нийслэлийн 50 сургуульд багшийн хөгжлийн танхимын тавилга, тоног төхөөрөмж, 30 сургуулийн цайны газарт гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг эхлүүллээ.**

Бага, дунд боловсролын чанарын үнэлгээний бодлогын баримт бичгийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлсний зэрэгцээ сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг үнэлэх багш, сургалтын менежерт зориулсан аргачлал боловсруулан хүргүүлэв.

“Бага насны хүүхдийг хөгжүүлэх арга зүй” сэдэвт үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг Японы Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр зохион байгуулав.

Албан бус боловсрол, зайны сургалтын “Гэгээрэл” төвүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургадаг 55, 63, 106, 29, 70 зэрэг тусгай сургуулиудын сургалтын орчинтой танилцан, тэдгээрт суралцагчдад мэргэжлийн боловсрол олгох ажил нэн түрүүнд шаардагдах тоног төхөөрөмжийн судалгааг нарийвчлан гаргалаа. Энэхүү тоног төхөөрөмжийг “Үр дүнд түргэн хүрэх санаачилгын төсөл”-ийн санхүүжилтээр нийлүүлэхээр тохиролцоод байна.

**Багш нарын үр дүнгийн урамшууллыг 2009 онд 10-15 хувиар сар бүр тооцон, улирал бүр олгож байхаар шийдвэрлэлээ.**

**Дээд болон мэргэжлийн боловсрол: Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлууллаа.**

Сургалтын төрийн сангаас дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчдын хамрагдах мэргэжлийн чиглэл, хуваарийг батлав.

Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн Удирдах зөвлөл дэх төрийн төлөөллийг шинэчлэн баталж, шинээр байгуулагдсан Удирдах зөвлөлүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх арга хэмжээ авч байна.

Монгол Улсын дээд боловсролын өнөөгийн байдлыг тодорхойлох, дээд боловсролын байгууллагуудын хүрсэн түвшинг олон улсын жишигтэй харьцуулан дүн шинжилгээ хийх, дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавих шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох зорилгоор дээд боловсролын 53 байгууллагаас судалгаа авлаа.

Катар Улсаас авах зээлийн хүрээнд ШУТИС, ХААИС, МУИС, ЭМШУИС-ын лабораториудыг бэхжүүлэх 4 төслийг холбогдох байгууллагад хүргүүлэх бэлтгэлийг хангасны зэрэгцээ ОХУ, Украйн, БНКУ-д хоёр улсын Засгийн газар хоорондын тэтгэлгээр суралцах 330 хүнийг бүртгэн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсад суралцаж буй гадаад оюутнуудтай уулзалт зохион байгуулав. Өнөөдрийн байдлаар манай улсад гадаадын 27 улсаас 1200 гаруй оюутан 51 их, дээд сургуульд суралцаж байгаагийн 170 нь хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу суралцаж байна. Уулзалтын үр дүнд гадаад оюутнуудын нийгмийн хамгаалал, суралцах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойллоо.

**Соёл, урлаг:** Монгол хөөмийн урлагийг хөгжүүлэхэд чиглэсэн олон ажлуудыг хэрэгжүүлж “Монгол хөөмий” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Монгол хөөмийн олон улсын симпозиум-наадам”-ыг 2009 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар шийдвэрлэн арга хэмжээний удирдамж, зохион байгуулах хороо, төсвийг тус тус баталлаа.

“Монгол төрийн түүхийн музей байгуулах тухай” Засгийн газрын 2009 оны 30 дугаар тогтоолоор Чингис хааны дурсгалын хөшөө, “Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө” цогцолборыг ашиглалтад хүлээн авсантай холбогдуулан Монгол төрийн түүхийн музейг Үндэсний музейн харъяанд байгуулан ажиллуулахаар шийдвэрлүүлээ.

**Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 370 жилийн ойг 2009 оны 10 дугаар сарын 29-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэв.**

Халимаг Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийх айлчлалын үеэр тус улсын соёлын өдрүүдийг зохион байгуулж, “Цагаан сарын домог” драмын жүжиг, 2 улсын хамтарсан урлагийн тоглолт, уран бүтээлчдийн уулзалт, фото зургийн үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулав.

АНУ-ын Хьюстон хотын байгалийн шинжлэх ухааны музейд “Чингис хаан” үзэсгэлэнг гаргаж, түүх, археологи, угсаатны зүйн чиглэлийн 156 үзмэрийг тавьсан бөгөөд үзэсгэлэн энэ оны 9 дүгээр сар хүртэл үргэлжилнэ.

Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд 2009-2011 онд соёлын салбарт хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж баталгаажууллаа. Энэ гэрээний дагуу соёл, урлагийн нарийн мэргэжлээр жил бүр 30 хүртэл тооны оюутан, мэргэжил дээшлүүлэгчийг ОХУ-д сургахаар тогтов.

Соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, түүнд бүртгэх журам, улс, орон нутгийн музейн үлгэрчилсэн дүрмийг тус тус шинэчлэн баталж, мөрдүүлж эхлээд байна.

БНАСАУ-д болох олон улсын уламжлалт “Хаврын баяр” урлагийн ХХҮИ их наадам, Франц Улсад болох найрал дууны олон улсын наадам, М.Магины нэрэмжит төгөлдөр хуурчдын олон улсын XIII уралдаан, Испани Улсад болох төгөлдөр хуурчдын олон улсын уралдаанд Монголын уран бүтээлчдийг оролцуулах асуудлыг шийдвэрлэн зохих бэлтгэлийг хангаж байна.

Шинжлэх ухаан, технологи: Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох ажлын Зохицуулах зөвлөлийг байгуулан, гүйцэтгэгч байгууллагатай байгуулах гэрээ байгуулах, уг ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах арга хэмжээ авлаа.

“Үндэсний инновацийн тогтолцоо ба мэдээллийн технологи” семинарыг Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газар, Мэдээллийн технологийн үндэсний паркттай хамтран зохион байгуулав. Семинарт төрийн болон төрийн бус байгууллага, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагуудыг төлөөлсөн 100 шахам төлөөлөгч оролцов. Оролцогч байгууллагуудаас мэдээллийн технологийн талаарх төрийн бодлого, түүний хэрэгжилт, салбарын хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашид авах арга хэмжээний талаар 9 илтгэл хэлэлцүүлж, төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэд, судлаачид, бизнес эрхлэгчдэд хандан зөвлөмж гаргалаа.

ШУА-ийн харъяа Байгалийн шинжлэлийн нэгдсэн лабораторид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 700.0 сая төгрөгийн нарийн судалгааны багаж төхөөрөмж шинээр нийлүүлсэн бөгөөд нээлтийн ажиллагааг 2009 оны 2 дугаар сарын 8-нд хийж, энэ үеэр “Байгалийн шинжлэлийн нэгдсэн лаборатори-2009” семинар зохион байгуулав.

## **Эрүүл мэндийн салбарт**

Засгийн газар эрүүл мэндийн салбарын байгууллагуудыг хөгжүүлэхэд анхаарч тэдгээрийг оношлогоо, эмчилгээний сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр ханган оношлогоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 дүгээр тушаалаар бөөр шилжүүлэн суулгах хагалгаа хийлгэсэн өвчтөнд тогтоосон төлбөрийн хэмжээнээс 8153.6 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлж байхаар тогтоолоо.

2008 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан эмнэлгийн тоног төхөөрөмжөөс 31.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ХӨСҮТ-д, 393.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Орхон аймгийн нэгдсэн эмнэлэгт, 210.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шинээр ашиглалтад орж байгаа болон нэгдүгээр шатлалын эмнэлгүүдэд, 79.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Яаралтай тусламжийн төвд, 719.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвүүдэд, 235.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эмнэлгийн аюултай хог хаягдал устгах төв байгуулахад зориулан нөөцөд, 2110.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад, 268.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийслэлийн амаржих газруудад тус тус олгохоор шийдвэрлэв.

**ДЭМБ-ын тусламжаар** олгосон 287.1 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг ХӨСҮТ, ЭНЭШТ, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 2008 оны төсөв, Дэлхийн зөн олон улсын байгууллагын хамтарсан хөрөнгө оруулалтаар худалдан авсан 481.5 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдлүүдэд тус тус хуваарилан олгосон байна.

**“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн санхүүжилтээр** худалдан авсан нэг бүр нь 648.3 мянган төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг нүдний угийн дуранг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвд олгожээ.

Эрүүл мэндийн яам болон “М Си Эс Электроникс” ХХК-ийн хооронд байгуулсан СТП-2008 гэрээний дагуу худалдан авсан 56.8 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг клиникийн эмнэлэг, төвүүдэд болон нийслэлийн эрүүл мэндийн газарт хуваарилан олголоо.

**Дэлхийн зөн байгууллагын Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн санхүүжилтээр** олгогдож буй эмнэлгийн түргэн тусламжийн зориулалтын Тоёото Ланд-круйзер маркийн 8 автомашиныг Булган, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай аймгийн нэгдсэн эмнэлэг, ЭМЯ-ны алсын түргэн тусламжийн төв, нийслэлийн яаралтай тусламжийн төв, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвд тус тус олголоо.

Хүний томуугийн 28000 хүн/тун вакциныг бүх аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хуваарилж, хэрэглэх зааврыг баталжээ. Мөн хуваарилсан вакцинаар аймаг, нийслэлийн хил, гааль, мэргэжлийн хяналт, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн байцаагч зэрэг эрсдэл бүхий бүлгийн хүн амыг тархвар

судлалын заалтаар дархлаажуулах арга хэмжээг энэ оны 3 дугаар сарын 20-ны дотор багтаан зохион байгуулав.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 41 дүгээр тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хандлага, харилцааны ур чадварын”, “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын мэргэжлийн”, “Цус сэлбэлт, судлалын салбар зөвлөл, түүний бүрэлдэхүүн”, “Мэдрэлийн мэргэжлийн салбар зөвлөл”, “Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл”-үүдийн бүрэлдэхүүнийг тус тус шинэчлэн батлав.

Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн зохицуулалтыг сайжруулах, олон талт хамтын ажиллагааны зохион байгуулалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн салбар дахь зээл, тусламжийг зохицуулах зөвлөлийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, ажиллах журам, төсөл, хөтөлбөрийн зохицуулагчдыг тус тус баталсан байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийг үндэслэн “Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтанд эрүүл мэндийн үзлэг хийх журам”, “Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил гүйцэтгэхэд хориглох өвчний жагсаалт”, “Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй холбоотой ажилд харшлах өвчний жагсаалт”-ыг тус тус баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Улаанбаатар төмөр замын эмнэлгийн албаны даргад үүрэг болгов.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэл, Цусны донор сонгох эрүүл мэндийн шалгуур, хориглох заалт, донорын эрүүл мэндэд шаардлагатай хийгдэх шинжилгээ болон чанарын шинжилгээний жагсаалт, цус цусан бүтээгдэхүүнийг авч боловсруулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах журам, цус, цусан бүтээгдэхүүнийг захиалж авах, сэлбэх журам, цусны аюулгүй байдалд хяналт тавих үүргийн хуваарилалт, цус сийвэн сэлбэлтийн дараах халдварыг бүртгэх, тооцох журам, цус цусан бүтээгдэхүүний нэгжийг тооцох журам, цусны албаны үйл ажиллагааны тайлангийн маягтуудыг тус тус баталж,

“Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор нийслэлийн нэгдүгээр амаржих газарт 27 нэрийн 267.9 сая төгрөгийн, хоёрдугаар амаржих газарт 14 нэр төрлийн 22.9 сая төгрөгийн, гуравдугаар амаржих газарт 15 нэрийн 24.4 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийг олголоо.

**Дээрх ажлуудыг хийснээр эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын техник хэрэгслийн хангалт нэмэгдэж, хүн амд үзүүлэх үйлчилгээ сайжирч байна.**

## **Төсөв, санхүүгийн талаар**

**Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралыг амжилттай даван туулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж байна.**

Монгол Улсын Засгийн газрын бондыг олон улсын зах зээлд арилжаалах бэлтгэл ажлыг хангах, арилжаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүний гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын бондыг олон улсын санхүүгийн зах зээлд гаргахтай холбогдуулан Голдман Сакс (Goldman Sachs), Дойче банк (Deutsche Bank), Хонконг Шанхайн банкны корпораци (HSBC), Морган Стэнли (Morgan Stanley) банкуудын ирүүлсэн техникийн ба санхүүгийн саналыг судлан нарийвчилсан үнэлгээ хийв.

**Улсын Их Хурлын 2009 оны 8 дугаар тогтоолоор зөвшөөрсөн Засгийн газрын үнэт цаасыг 2009 оны төсвийн жилд багтаан Монголбанк болон банк, санхүүгийн бусад байгууллагад арилжаалахыг Сангийн сайдад зөвшөөрсөн байна.** Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 300 хүртэл тэрбум төгрөгийн бондыг төсвийн дотоод тэнцлийг хангах, зарлага санхүүжилтийн эх үүсвэрийн дутагдлыг нөхөхөд зориулан эхний ээлжинд 60.0 тэрбум төгрөгийн бондыг Монголбанкинд арилжиж, үлдэх бондыг бусад банк, санхүүгийн байгууллага болон нийтэд арилжаалахаар төлөвлөсөн байна.

**Монгол Улсын 2008 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын талаар: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2156.4 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 351.5 тэрбум төгрөгөөр буюу 14.0 хувиар тасарч, харин 2007 оны мөн үеийнхээс 275.9 тэрбум төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна.**

Нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задалбал татварын орлогоор 87.6 хувийг, татварын бус орлогоор 11.5 хувийг, хөрөнгийн ба тусламжийн орлогоор 0.9 хувийг бүрдүүлсэн байна. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад орлогын албан татварын орлого 14.6 хувиар буюу 129.6 тэрбум төгрөгөөр, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 10.7 хувиар буюу 65.8 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 29.7 хувиар буюу 104.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн явдал голлон нөлөөлсөн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2008 оны батлагдсан төлөвлөгөөгөөр 2529.2 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 1815.6 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр 2462.0 тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 1736.7 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 97.3 хувийг (улсын төсвийн зарлагын 95.7 хувийг) санхүүжүүлсэн бөгөөд 2007 оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 983.9 тэрбум төгрөгөөр буюу 66.6 хувиар (улсын төсвийн зарлага 2007 оны мөн үеийнхээс 83.7 тэрбум төгрөгөөр буюу 5.1 хувиар) өссөн байна.

Монгол Улсын төсвөөс 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн тавьж олгосны зэрэгцээ халамжийн сангаас хүүхдийн мөнгө хөтөлбөрт 33.2 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмжид 8.8 тэрбум, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 6.5 тэрбум, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 17.5 тэрбум, цэргийн тэтгэвэр, тэтгэмжид 5.6 тэрбум, алдар цолтой ахмад настанд олгох нэмэгдэлд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын 12.4 хувь буюу 217.4 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн арга хэмжээнд, 33.3 хувь буюу 590.3 тэрбум төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, өөрөөр хэлбэл, нийт урсгал зардлын 46.2 хувь буюу 807.7 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжид зарцуулсан байна.

Орон нутаг 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөөг 0.6 хувиар буюу 1.2 тэрбум төгрөгөөр тасалж, төсвийн зарлагын 96.8 хувийг буюу 7.0 тэрбум төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас 53.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 42.8 тэрбум төгрөгийг оруулж, харин улсын төсөвт

төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Өмнөговь, Сүхбаатар, Орхон аймаг 2.1-5.7 тэрбум төгрөгөөр тасалсан байна.

Монгол Улсыг хөгжүүлэх санд 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр зарим бараа бүтээгдэхүүний албан татвараар 388.7 тэрбум төгрөг төвлөрүүлж, сангийн хөрөнгөөс 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид 89.2 тэрбум, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулийн дагуу их бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 252.3 тэрбум, улсын хэмжээнд бензин, шатахуун, улаан буудайн нөөц бүрдүүлэх ажилд 76.4 тэрбум, ноолуурын үнийн уналттай холбогдуулан малчдад олгох нэг удаагийн мөнгөн тусламжид 24.6 тэрбум төгрөгийг **(нийт 442.5 тэрбум төгрөг)**-ийг зарцуулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн *(өссөн дүнгээр)* 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 386.6 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 305.7 тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 54.5 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 294.0 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан байна.

Улсын төсөвт байгууллагын төсвийн зарлагын 2008 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр (2008 оны арванхоёрдугаар сарын 31-ний үлдэгдэл) төсөвт байгууллагын төсвийн нийт авлага 7.2 тэрбум, төсвийн нийт өглөг 4.6 тэрбум төгрөгт хүрч, 2008 оны эхний үлдэгдлээс улсын төсвийн байгууллагын авлага 2.0 тэрбум, өглөг 0.1 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн байгууллагын авлага 0.3 тэрбум, өглөг 0.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Харин Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зүгээс өр барагдуулах ажлыг эрчимтэй зохион байгуулж, улмаар төсвийн багцын зардлын зүйл, ангийн болон байгууллага хооронд гүйлгэн зарцуулах зохицуулалт хийж, төсвийн байгууллагууд жилийн эцэст өр төлбөргүй гарахын төлөө хүчин чармайлт тавьж ажилласны дүнд 2008 оны 11 дүгээр сарын үлдэгдлээс төсвийн өглөгийн хэмжээ 5.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монгол Улсын 2009 оны төсвийн орлогын ба төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь, Улсын төсвөөс 2009 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хуваарь, Орон нутгийн төсвөөс 2009 оны төсвийн жилд улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хуваарь, Нийгмийн даатгалын сангуудын 2009 оны сар, улирлын хуваарь, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын сар, улирлын хуваарь, Улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн сарын хуваарь, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2009 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн сарын хуваарийг тус тус баталж мөрдүүлээ.

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулиудын дөрөв дэх хэлэлцүүлгийг УИХ-ын ээлжит бус чуулганы хуралдаанаар батлуулсан байна. Үүний дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны нийт орлогыг 1973.0 тэрбум төгрөгөөр (ДНБ-ний 31.3 хувь), нэгдсэн төсвийн 2009 оны нийт зарлагыг 2314.2 тэрбум төгрөгөөр (ДНБ-ний 36.8 хувь), баталж, нийт алдагдлыг 341.2 тэрбум төгрөгөөр буюу ДНБ-ний 5.4 хувьтай тэнцэх хэмжээнд байлгах аар зөвшөөрсөн байна.

Төсвийн үрсгал зарлагыг бууруулах арга хэмжээний хүрээнд: 1) Улсын төсвөөс хүүхдэд сар бүр олгодог 3000 төгрөгийг үргэлжлүүлэн олгож, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас улирал тутам олгодог 25.000 төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн үлдэгдэлтэй уялдуулах;

2) Шинээр гэрлэгчдэд олгож буй 500.000 төгрөгийг 300.000 болгож, 6.6 тэрбум төгрөгөөр зардлыг бууруулах;

3) Шинээр төрсөн хүүхдэд олгох 100.000 төгрөг, Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламжийг үргэлжлүүлэн олгох;

4) Зарим төрлийн нийгмийн халамжийн тэтгэмжийн давхардлыг арилгах;

5) Төрийн нийт албан хаагчдын цалинг гуравдугаар сарын 1-нээс эхлэн нэг жилийн хугацаанд 20 хувиар, төрийн өндөр албан тушаалтны цалинг 30 хувиар (нийт 98.6 тэрбум төгрөгөөр) бууруулах;

6) Төсөвт байгууллагын бараа, үйлчилгээний зардлыг багасгаснаар 25.3 тэрбум төгрөг хэмнэх;

7) Орон тоог нэмэгдүүлэхгүй байх, орон тооны хязгаараас хэмнэгдэж байгаа, сул буй орон тоо, тэтгэвэрт гарч буй иргэний оронд шинээр ажилтан нэмж авахгүй байхаар тогтсон байна.

Хөрөнгө оруулалтыг хүмий арга хэмжээний хүрээнд: 2009 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хойшлуулах, өмнөх онд барихаар төлөвлөгдөж 2009 онд шилжиж байгаа боловч тендер зарлагдаагүй, барилгын ажлын гэрээ байгуулагдаагүй, гэрээ байгуулсан хэдий ч барилга угсралтын ажил эхлээгүй, санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хойшлуулах зэрэг арга хэмжээ авснаар улсын төсвийн хөрөнгө оруулалт батлагдсанаас 130 гаруй тэрбум төгрөгөөр бууруулахаар өөрчлөлт оруулав.

Банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Банкин дахь хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг УИХ-аар батлуулж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкин дахь иргэдийн мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргасан билээ. Хууль батлагдсанаас хойшхи хугацаанд хадгаламжийн хэмжээ 15.2 тэрбум төгрөгөөр буюу 1 хувиар өссөн хэдий ч харилцах дансны үлдэгдэл 29.6 тэрбум төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан нь банкин дахь харилцахад төрөөс баталгаа гаргаж, мөнгөний гадагшлах урсгалыг зогсоох зайлшгүй шаардлагатай болсныг харуулж байна. Үүнтэй холбогдуулан “**Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль**”-д нэмэлт, өөрчлөлт оруулах замаар банкин дахь иргэний ба хуулийн этгээдийн харилцах дансны үлдэгдлийг баталгаанд нэгэн адил хамааруулахаар тооцож хуулийн төслийг боловсруулж байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж, үүнтэй холбогдуулан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-аар батлуулсан байна.

**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг УИХ-аар батлуулж, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалтыг хилийн боомтын нэр төрлөөс хамааруулан ногдуулах онцгой албан татварын хэмжээг автобензинд 90 хүртэл октантай бол 0-252 мянга, 90 ба дээш октантай бол 0-259 мянган төгрөгөөр, дизелийн түлшинд 0-265 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, мөрдүүлсэн байна. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ огцом өсөж, ОХУ нефть төрлийн бүтээгдэхүүний экспортын татвараа нэмснээр манай дотоодын зах зээлд онцгой хүндрэл үүссэн тул 2008 оны 5 дугаар сард УИХ-аас хэд хэдэн хуульд өөрчлөлт оруулж, Засгийн газар 2008 оны 6 дугаар сард импортоор нийлүүлж буй авто бензин, дизелийн түлшний нэмэгдсэн өртгийн албан татварыг “5” хувиар, онцгой албан татварын тарифыг “0” хувиар тогтоосон билээ. Ингэснээр газрын тосны бүтээгдэхүүний дотоодод борлуулах үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгахад зохих нөлөө үзүүлсэн байна.**

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг илүү боловсронгуй болгох зорилгоор хуулийн төсөл боловсруулж байна.

**УИХ-ын 2009 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг зохион байгуулах, шуурхай удирдлагаар хангах үүрэг бүхий Түр хороог байгуулж, түүний ажиллах журмыг Засгийн газрын 2009 оны 66 дугаар тогтоолоор баталлаа.**

**Засгийн газрын 2009 оны 68 дугаар тогтоолоор Монгол Улсыг хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгөөс Монголшуудан банкинд 25.0 тэрбум, Зоос банкинд 15.0 тэрбум төгрөгийг 180 хоногийн хугацаатай, жилийн 9.75 хувийн хүүтэй тус байршуулахаар шийдвэрлэв.**

**Монгол Улсын Засгийн газар-Гадаад түнш нарын хамтарсан 5 дахь удаагийн уулзалтыг Дэлхийн банктай хамтран амжилттай зохион байгуулж, олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас нийт 160.0 сай ам. долларын хөнгөлөлттэй зээл авахаар болсон байна.**

**Түүнчлэн ОУВС-тай хамтран санхүү, эдийн засгийн хямралын нөхцөлд 224.0 сая ам. долларын хөтөлбөрийг 18 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр тохиролцоонд хүрсэн байна.**

Япон Улсаас Монгол Улсад 2008 оны санхүүгийн жилд олгох Ерөнхий буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Дархан хотын усан хангамжийг сайжруулах” төсөл, “Бага, дунд боловсролын сургуулийн барилга, өргөтгөл барих” төслийн 4 дэх үе шат, “Улаанбаатар хотод гүүрэн гарц барих” төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, мөн Соёлын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Хархорины музей барих”, “Хүүхэлдэйн театрын техникийн шинэчлэл” төсөл хэрэгжүүлэх хоёр Засгийн газар хоорондын Солилцох ноот бичгүүдэд Гадаад харилцааны сайд, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрх элчин сайд нар, түүнчлэн Нарийвчилсан зураг төсөл боловсруулах, төсөл хэрэгжүүлэх зорилго бүхий Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хооронд байгуулах тусламжийн хэлэлцээрт Гадаад харилцааны сайд, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Төлөөлөгчийн газрын дарга нар тус тус гарын үсэг зурлаа.

Эдгээрээс “Хархорины музей барих” төсөлд 495.8 сая иен, “Хүүхэлдэйн театрын техникийн шинэчлэл” төсөлд 44.9 сая иен зарцуулахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Их түмэн санаачилгын Зөвлөлдөх хорооны 10 дахь уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Их түмэн санаачилгын Зөвлөлдөх хорооны уулзалтаас “Улаанбаатарын тунхаглал”-ын баримт бичгийг баталж, Зүүн хойд Азийн Бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Тээврийн зөвлөл, Худалдааг хөнгөвчлөх зөвлөл, Зүүн хойд Азийн Худалдааны танхимыг шинээр байгуулахаар тохиролцов.

**Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөг бууруулах, даван туулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр төсвийн үргүй зардлыг бууруулж, хязгаарлагдмал нөөцийг шаардлагатай гол бодлого, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулж, хүн амын амьжиргааг бууруулах сөрөг нөлөөллийг багасгаж байна.**

### **Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр**

**Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр авто зам, тээвэр, барилгын салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болон хэрэгжүүлж байгаа төслүүдийн санхүүжилт хүндэрч байна. Засгийн газар юуны өмнө улсын нийгэм, эдийн засаг, иргэдийн амьжиргаа нэн тэргүүнд нөлөөлөх төслүүдэд хөрөнгө зарцуулах бодлого баримталж байна.**

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрдэнэт-Булган-Уньтын 146 километр авто зам барих төсөл”-ийн хүрээнд баригдах Булган-Уньтын чиглэлийн 74 километр авто замын гүйцэтгэгч “Нарсны зам” ХХК-ийн 2009 онд гаалийн ба нэмэгдсэн өртгийн татваргүйгээр импортлох 100 нэр төрлийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сэлбэг, эд анги болон зарим бараа материалын жагсаалтыг баталж, улсын хилээр оруулах, мөн Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 432 километр авто зам барих “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх” төслийн хүрээнд Багц Б1-ийн гүйцэтгэгч China Geo-Engineering Corpation, Багц NP1, AR2-ын гүйцэтгэгч Shengli Engineering and Construction Company-иудын 2009 онд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татваргүйгээр нийлүүлэгдэх нийт 85 нэр төрлийн тоног төхөөрөмж, машин механизм, бараа, материалын жагсаалтыг баталж, улсын хилээр оруулах зөвшөөрлийг олгосон байна.

Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалтын ажлын 2009 оны төлөвлөгөөг баталж, улсын чанартай авто зам, гүүрийн арчлалт, урсгал засварын 52 төрлийн ажилд 7455.9 сая, зам, гүүрийн их засвар, зураг төсөл, үйлдвэрлэлийн баазын бэхжүүлэх зэрэг 10 төрлийн ажилд 1621.4 сая, авто замын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зардалд 125.0 сая, нийт 9202.3 сая төгрөгийг зарцуулахыг зөвшөөрсөн байна.

Улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтын 2009 төлөвлөгөөг баталсан бөгөөд Улаанбаатар хотын авто замыг сайжруулах чиглэлээр “100.0 тэрбум төгрөг” төслийг боловсруулав.

Автомашин ажилласан жил болон хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжаас нь хамааруулан онцгой татвар ногдуулах, бага оврын автобус болон ачааны автомашиныг

онцгой татварт хамруулах, технологийн тээврийн хэрэгслийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх чиглэлээр хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулав.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, БНСУ-ын “Daewoo bus global corporation”-ны хооронд байгуулсан гэрээний дагуу улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдэх их багтаамжийн 400 автобусны эхний ээлжийн 60 автобусыг нийслэлийн “Автобус-1” НӨУҮГ-т хүлээлгэн өгч Улаанбаатар хотын зарим чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд явуулж эхлээд байна.

**Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн Зөвлөх компанийг сонгон шалгаруулах тендерийг зарлах зөвшөөрлийг аваад байна.**

“Чингис Хаан” ОУНБ-ын хөөрч, буух зурвасны хүчитгэлийн ажлыг гүйцэтгэхээр шалгарсан “China Geo Engineering Co., Ltd” компани заасан хугацаанд гэрээ байгуулаагүй тул эрхийг цуцалж, 2009 оны төсөвт тусгагдсан 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн хэмжээнд дахин тендер зарлахаар үнэлгээний хороо томилогдон ажилдаа ороод байна.

Агаарын харилцааны тодорхой асуудлын тухай Монгол Улсын Засгийн газар, Европын хамтын нийгэмлэг хоорондын Хэвтээ тэнхлэгийн хэлэлцээрийн төслийн бичвэрийг тохирох уулзалт хэлэлцээг Брюссель хотноо хийж Хэлэлцээрийн төсөлд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулан үзэглээд байна.

Агаарын хөлгийн шатахуун нийлүүлэх үйлчилгээнд шударга өрсөлдөөнийг буй болгох, Иргэний нисэхийн Ерөнхий газрын өмчид байдаг шатахууны агуулахыг ашиглалтад оруулах зорилгоор шатахууны сав, байгууламжид шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэн, шатахуун нийлүүлэх үйлчилгээ эрхлэх нөхцөлөөр тендер зарлаж, шатахуун үйлчилгээний хоёрдох аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.

“Транзит Монгол” Олон Улсын чуулга уулзалтыг зохион байгуулж, манай Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, ОХУ-ын “Оросын төмөр зам” нээлттэй хувьцаат нийгэмлэг, БНСУ-ын Төмөр замын сулжээний хэрэг эрхлэх газрын хооронд “Транзит Монгол” санамж бичиг, мөн Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, ХБНГУ-ын “Дойче Баан” ХК-ын хооронд төмөр зөмөн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулж, “Транзит Монгол” тунхаг бичгийг батлан гаргалаа.

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хувь нийлүүлэгчдийн хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, энэхүү хурлын протоколыг харилцан тохиролцож холбогдох талуудаар баталгаажуулав.

ТЗХАБ-ын хүрээнд зохион байгуулагддаг төмөр замаар тээвэрлэгддэг ачааны хэмжээ тохирох хуралд оролцож 2009 онд тээвэрлэх экспорт, импорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээг эцэслэн тохиролцлоо. Үүний дагуу дамжин өнгөрөх тээвэр 3.2 сая, экспорт 4.5 сая/, импорт 1.6 сая тн ачааны хэмжээг тус тус тохирсон болно.

Далайн нэхэмжлэлийн хариуцлагыг хязгаарлах тухай 1976 оны конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1996 оны протоколд нэгдэн орох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-ын холбогдох байнгын хороогоор оруулж хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

**Барилга, орон сууцны чиглэлээр: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “10000 орон сууц” төслийг эхний хувилбараар боловсруулж, энэ талаар Монголын барилгачдын холбоотой хамтран ажиллах Санамж бичиг байгуулан ажиллахаар тохиролцлоо.**

ХБНГУ-ын Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн боловсролын салбарыг дэмжих” хөтөлбөртэй “100 000 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулав.

Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж буй “Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөл” болон Япон Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх МОН-9106 төсөл”-ийн удирдах хорооны хурлыг зохион байгуулж, төслийн хүрээнд 2009 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний төсөл, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Япон Улсын “Сайто Масао” архитектурын компанийн төлөөлөгчидтэй уулзалт хийж, цаашид хамтран ажиллаж амины орон сууц барих төсөл хэрэгжүүлэхээр тохиролцов.

### **Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын талаар**

**Монгол Улсын хөгжилд гол түлхэц болох стратегийн орд газруудын хөрөнгө оруулалтын гэрээг байгуулан эргэлтэд оруулж, орлогоос нь иргэддээ хувь хүртээх, ордуудыг дагасан томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.**

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр: 2007 онд гарын үсэг зурсан Монгол-Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг УИХ-д өргөн мэдүүлж Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороогоор хэлэлцүүлэв.

**Оюутолгойн зэс-алтны орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулж байгаа бөгөөд Тавантолгойн нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар олон улсын зөвлөх компанийг шалгаруулав.**

Цагаан суваргын зэс-молибдений ордын хайгуулын ажлын тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан төсөлд шүүмж гаргахаар ажлын хэсэг ажиллаж байна.

Дэлхийн банкнаас санхүүжүүлэх “Уул уурхайн техник туслалцааны төсөл”-ийн ажлыг эхлүүлэх чиглэлээр ажиллаж, төслийг эхлүүлэхэд шаардлагатай баримт бичгийг боловсруулан Дэлхийн банкинд хүргүүлсэн.

“Нүүрсний экспортын өнөөгийн байдал, түүнд тулгарч буй хүндрэл” асуудлаар санал солилцох уулзалт, “Ашигт малтмалын ордын геологи ба эрэл хайгуулын асуудал” чуулга уулзалтыг зохион байгуулав.

Уул уурхайн салбар, газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниудад шаардагдах валютыг тогтвортой ханшаар худалдаж байх асуудалд Монголбанктай хамтран ажиллахаар санал хүргүүлээд байна.

**Уул уурхайн салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн “Хариуцлагатай уул уурхай” сэдэвт зөвлөлгөөнийг зохион байгуулав.** Зөвлөгөөнд 100 гаруй жижиг, дунд уул уурхай эрхлэгчид оролцож, ашигт малтмалыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, эдийн засгийн үр ашигтайгаар олборлоход зайлшгүй мэдвэл зохих хууль эрх зүй, эдийн засаг болон бусад шаардлагатай мэдээллийг хүлээн авч, харилцан санал солилцов.

**Бичил уурхайн бодлого боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж Бичил уурхайн хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан.**

**Төв аймгийн Борнуур суманд бичил уурхайн загвар үйлдвэрийг ашиглалтад хүлээн авав.** Энэ нь тус суманд алтны үндсэн ордын хүдрийг нэг цэгт төвлөрүүлэн боловсруулах аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулж бичил уурхайчдын ажлын байрыг хадгалах, үндэсний хэмжээнд загвар болохуйц бичил уурхайн менежментийг хөгжүүлэх замаар нийгмийн сэтгэл зүйд үүсээд байгаа сөрөг имиж, төсөөллийг арилгах, хөдөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах ажлын эхлэл болж байгаа юм.

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт гадаад орон олон улсын байгууллагын 123.4 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 6 төсөл, 43.5 сая ам. долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 7 төсөл хэрэгжиж байна.

Эрчим хүчний чиглэлээр: “Эрчим хүчний төсөл”-ийн хүрээнд байгуулсан 5 гэрээний 329.3 мянган, “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах төсөл”-ийн 16.7 мянган, “Орон нутгийн дулаан хангамжийг сайжруулах төсөл”-ийн 3 гүйцэтгэгчийн 130.9 мянган ам. долларын гүйцэтгэлийг тус тус хянаж, “Дамжуулах сүлжээний шинэчлэлт төсөл”-ийн хүрээнд гадаад орноос оруулж байгаа 40.4 мянган ам. долларын сэлбэг, бараа, материалыг зээлийн гэрээний дагуу гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэв.

Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний цогцолбор барих төслийн ажлын хэсгүүдийн 8 дугаар уулзалт, “Их түмэн санаачилга” механизмын зөвлөлдөх хорооны 10 дугаар уулзалтыг зохион байгуулав.

Улаанбаатар хотын “ДЦС-5”-ийн станцын тендерийг нээж, үнэлгээний ажлыг хийж байна. “ДЦС-2” төрийн өмчит хувьцаат компанийг түшиглэн “Дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал түлш болон хийгээр эрчим хүч үйлдвэрлэх цогцолбор” байгуулах тендерийг зарласан боловч шаардлагад нийцсэн оролцогч байгаагүй тул тендер шалгаруулалтыг хүчингүй болгож, дахин тендер зарлаад байна.

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн Төмөртэйнбулаг төмрийн хүдэр олзворлох үйлдвэрийн цахилгаан хангамжийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах 2009/07 тоот даалгавар олгов.

Дөргөний усан цахилгаан станцыг ослын байдалтай зогсоосонтой холбогдуулан станцын хэвийн ажиллагааг хангах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Германы KFW банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд Дарханы дулааны цахилгаан станцын турбогенераторыг шинэчлэх төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулах ажлын хэсгийг байгуулж байна. Мөн тус банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслийн хүрээнд дэд станцуудын аккумуляторын байр барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлав.

Швед Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах” төсөл, Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа

Эрчим хүчний төслийн 2009 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг төслийн удирдах хороогоор тус тус батлав.

**Дэлхийн банкны тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах төсөл”-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн Алтай сум, Баянтоорой баг, Завхан аймгийн Ургамал, Дөрвөлжин зэрэг 4 суманд нарны цахилгаан станц байгуулах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, дүгнэлтийг Дэлхийн банкаар хянуулж байна.**

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Орон нутгийн дулаан хангамжийг сайжруулах” төслийн хүрээнд дулаан хангамжийг нь сайжруулах сумдын жагсаалтыг гаргав.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа “Бага орлоготой өрхийн эрчим хүчний хэмнэлт, агаарын бохирдлыг бууруулах төсөл”-ийн буцалтгүй тусламжийн гэрээг байгуулав. Мөн ХБНГУ-ын Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг болон Европын холбооны хамтарсан санхүүжилттэй “Монгол Улсын хот суурин газрын халаалтын системийн сайжруулалт” төслийн гэрээг байгуулав.

**Эрчим хүчний алдагдалтай ажилладаг үйлдвэрүүдэд алдагдлын татаас сар бүр олгож байна. Үүнд: “Баруун бүсийн эрчим хүчний систем” хувьцаат компанид 200.0 сая, Даланзадгадын дулааны цахилгаан станцад 67.0 сая, Налайхын дулааны станцад 60.0 сая, Багануурын дулааны станцад 100.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.**

Завхан аймгийн Улиастай, Тосонцэнгэл сум, Говь-Алтай аймгийн төвийн эрчим хүчний үйлдвэрүүдэд 2009 онд хэрэглэгдэх дизелийн түлшний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээг хийж, гэрээ байгуулах хэлэлцээр хийж байна.

### **Байгаль орчны чиглэлээр**

**Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчинд үүссэн хор нөлөөг арилгах, цаашид бууруулахыг зорьж байна.**

“Аюултай хог хаягдал устгах, аюулгүй болгох зориулалтын байгууламж бүхий төвлөрсөн цэг байгуулах” олон улсын нээлттэй тендер зарлан Унгар улсын “Коёрниезетехнология” КФТ-г гүйцэтгэгч байгууллагаар шалгаруулаад байна. Энэ ажлын хүрээнд 9 аймгийн Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулан хашиж, хариуцах эзэнтэй болгож, хог хаягдлаар бохирдсон 90.4 га талбайн хог хаягдлыг цэвэрлэж зайлуулан, 5 аймагт хаягдал гялгар уут, хуванцар боловсруулах бага оврын үйлдвэр байгуулж, хог хаягдлын төвлөрсөн цэгт ландфилл хийх зориулалт бүхий 31 техник хэрэгсэл худалдан авч хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхгүй байх, хогноос үүсэх хор холбогдлын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллав. **Уг ажлыг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 1050.0 сая, орон нутгийн төсвөөс 296.0 сая, нийт 1346.0 сая төгрөг зарцуулсан байна.**

6 аймгийн 16 сумын 125 цэгт хуримтлагдсан 72210 м<sup>3</sup> буюу 108315 тн шламыг тээвэрлэж, химийн бодисоор бохирдсон 34 552 м<sup>2</sup> талбайд хөрс хуулалт хийн саармагжуулж, 60 330 тн хаягдлыг булшлав. Боловсруулсан 10400 тн шламаас 6.65 кг мөнгөн ус, 5.53 кг алт ялган авлаа.

Төв, Сүхбаатар, Дорноговь аймгийн химийн бодисоор бохирдсон хаягдлыг зөөн тээвэрлэх, хоргүйжүүлэх ажлыг дуусгаж, Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь аймгуудад үйл ажиллагааг явуулж байна.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Сул уул гэдэг газарт гар аргаар алт олборлогч "Мэргэшсэн нинжа" гэгдэх 1200 орчим иргэн, 100 орчим машин ирж алт олборлож байгааг зогсоох зорилгоор Хөвсгөл аймгийн Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын алба, Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын газрын ажилтнууд болон хэвлэл мэдээлэл, иргэний хөдөлгөөний 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг газар дээр нь ажиллаж байна.

**Цөлжилтийг сааруулах, ойжуулалтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.** "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр бүх шатны сургууль, цэцэрлэгүүдийн дунд "Ногоон төгөл" уралдааныг зохион байгуулснаар 400.000 гаруй мод бут тарьж, 5100 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлж, 20000 гаруй сав цэцэг тарьж сургууль, анги танхимаа цэцэгжүүлжээ. Мөн 19 гудамж, талбай, цэцэрлэгүүдийг хариуцан хамгаалж, арчлан ургуулж байгаагаас гадна Туул, Булган голын ай сав газрын унаган төрх, хэв шинжийг нь хамгаалсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын 6 нөхөрлөлийн ойн бүртгэл тооллогын тайлан, ойн менежментийн төлөвлөгөө, 2 аж ахуйн нэгжийн ойн тооллого бүртгэлийн тайланг 1:50000 масштабтай ойн тархалтын зурагийг ой усны хайгуул судалгааны төвөөс гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, ойн ангийн дарга нарыг оролцуулсан удирдах ажилтны зөвлөгөөн, "Ойн тухай хуулийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээ" сэдэвт семинар, "Усны эрүүл ахуй, гэрэлт ирээдүйн төлөө эх дэлхийгээ ажиглацгаая" сэдэвт онол практикийн бага хурал зохион байгууллаа.

"Нэг жуулчин-нэг мод" санаачилгыг өрнүүлж 5 жуулчны баазад эхлүүлж байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг дэмжих замаар ядуурлыг бууруулах төслийн нээлтийг Хэнтий амгийн Дадал сум, Онон Балжийн БЦГ-т зохион байгуулж үйл ажиллагааг нь эхлүүллээ.

**Байгаль орчны доройтлоос шалтгаалан ан амьтдын амьдрах орчин нөхцөлд орж буй сөрөг өөрчлөлтөөс урьдчилан сэргийлж байна.**

Бэлчээр шахагдаж цаг агаарын байдал хүндэрснээс ан амьтны амьдрах нөхцөл хумигдаж байгаа тул тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадаас ан амьтдад зориулан биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. **Говь-Гурван сайханы байгалийн цогцолбор газар, Мөнххайрханы байгалийн цогцолбор газарт 20-400 орчим кг хужир шүү тавьж, Хөвсгөлийн байгалийн цогцолбор газарт 7 цэгт харз ус задгайлсны зэрэгцээ ажиглалт судалгааг хамгаалалтын захиргаа бүр явуулж холбогдох арга хэмжээг цаг тухай бүр авч хэрэгжүүлж байна.**

Дөргөний Усан цахилгаан станц ажилласнаас хойш загас өнгөрөөх сувгийг огт ажиллуулахгүй байгаа нь байгаль экологид сөрөг нөлөө үзүүлж байгаа тул Хар-Ус нуурын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаанаас усан цахилгаан станцын захиргаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

Цас ихтэй, ургамлын гарц муу байгаагаас хар сүүлт, монгол бөхөн, цоохор ирвэс зэрэг ан амьтад тал руу бууж байгаа тул хамгаалалтыг чангатгах арга хэмжээ авч байна.

Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 2009 оныг “Иргэдтэй хамтран ажиллах жил” болгон уриалга гаргаж биотехникийн арга хэмжээг 9 удаа 14 цэгт хийж, 9 цэгт харз ус задгайлж, 5 цэгт чонын ав тойлго хийж, ажиглалт судалгааг 15 удаа хийж гүйцэтгэжээ.

Хэнтий аймгийн Дархан сум, Говь-Алтай аймгийн нийт нутгийн 70 гаруй хувь нь гантай, гандуу байснаас өвөлжилтийн байдал хүндэрч зарим нутагт аргаль хонь, янгир ямаа өлдөж үхэж хорогдох нөхцөл бий болсонтой холбогдуулан нэмэлт өвс тэжээл, хужир мараа тавих биотехникийн арга хэмжээг байгаль хамгаалах “Салхин сандаг” нөхөрлөлтэй гэрээ байгуулан зохион байгуулж байна. Тэрчлэн тус аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зохион байгуулан Тайшир сумын “Улаан боом” гэдэг газарт мөсөөр хүрээлэгдсэн /арал/ ууланд байсан 20 гаруй янгир ямаанд 50 боодол өвс тавьж өгчээ.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Биологийн төрөл зүйлийг хамгаалах төв барих” төслийн үндсэн зураг төслийн судалгааны багтай хэлэлцээ явуулж, холбогдох протоколд гарын гарын үсэг зурсан байна.

2009 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, түүнийг хэрэглэх хэмжээ, Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг тус тус батлав.

Агаарын шинжилгээ. Шинжилгээний дүнгээс үзэхэд хүхэрлэг хийн дундаж агууламж  $0.037 \text{ мг/м}^3$ , хамгийн их нь  $0.102 \text{ мг/м}^3$  хүрч, нийт 129 удаагийн ажиглалтаар Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол 105 удаа ажиглагдлаа.

Азотын давхар ислийн дундаж агууламж  $0.027 \text{ мг/м}^3$ , хамгийн их нь  $0.062 \text{ мг/м}^3$  хүрч, нийт 143 удаагийн ажиглалтаар хүлцэх агууламжаас давсан бохирдол 29 удаа ажиглагдсан байна. Нүүрстөрөгчийн дутуу ислийн дундаж агууламж  $3.264 \text{ мг/м}^3$ , хамгийн их нь  $10.17 \text{ мг/м}^3$  хүрч, нийт 72 удаагийн ажиглалтаар хүлцэх агууламжаас давсан бохирдол 2 удаа ажиглагдав. Агаар дахь тоосны (PM10) дундаж агууламж  $0.076 \text{ мг/м}^3$ , хамгийн их нь  $0.156 \text{ мг/м}^3$  хүрч, нийт 18 удаагийн ажиглалтаар хүлцэх агууламжаас давсан бохирдол 6 удаа ажиглагдсан байна.

Усны шинжилгээ. Туул голын ус хотоос дээш хэсэгт “MNS4586-98” Усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдолгүй цэвэр байсан ба хотоос доош буюу Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн хаягдал нийлсэн хэсэг болон Сонгиноос Алтанбулаг сум хүртэлх хэсэгт голын усан дахь аммонийн азотын агууламж хүлцэх агууламжаас 5.8- 44.9 дахин, нитритийн азотын агууламж хүлцэх агууламжаас 1.7 дахин, эрдэс фосфорын агууламж хүлцэх агууламжаас 7 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч агууламж хүлцэх агууламжаас 2.8- 24 /24-с их/ дахин, переманганатын исэлдэх чанарын агууламж хүлцэх агууламжаас 1.5 дахин, фторын агууламж хүлцэх агууламжаас бага зэрэг давсан бохирдол илэрчээ. Сонгины доод цэгийн орчим аммонийн азотын болон биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч агууламж их бохирдлын хэмжээнд хүрсэн байна.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын дүүрэг дэх 5 цэвэрлэх байгууламжийн орох, гарах нийт 10 цэгээс сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнгээс харахад цэвэрлэх байгууламжуудаас гарч байгаа ус 9-71%-ийн цэвэршилттэй байгаа ба сорьц авах үед Төв цэвэрлэх байгууламж 69%-ийн цэвэршилттэй байсан байна.

3 дугаар сарын эхний 10 хоногийн байдлаар хийсэн зургаас харахад нийт нутгийн 71.8 хувь буюу ихэнх нутгаар цастай байлаа.

### **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн талаар**

**Засгийн газар хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлэн дотоодын хүнсний хэрэгцээг үндэсний үйлдвэрлэлээр хангадаг болох зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.**

БНБУ-ын Хөдөө аж ахуй, хүнсний сайд тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр “Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамтран ажиллах Протокол”-д гарын үсэг зурав.

Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, ОХУ-аас манай орны хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг шийдвэрлэв.

Монгол орны хөрс, цаг уур, агротехнологийн шаардлагад нийцсэн хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн үнийг харьцуулан судалж, ОХУ-аас эхний ээлжинд авах 70.0 сая ам. долларын үнэ бүхий техникийн жагсаалт, тоо хэмжээг гаргаж хүргүүлэв.

“Атрын гурав дахь аян”–тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар Засгийн газрын тогтоол гарган ажиллаж байна.

Атрын-III аяны хүрээнд Говь-Алтай аймгийн үйлдвэрлэгчдээс ирүүлсэн захиалгын дагуу “Хүлэмжийн аж ахуй эрхлэх” сэдэвт, Хэнтий аймгийн ХААНТ-ийн захиалгаар “Газар тариаланг эрчимжүүлэх, цомхотгосон техник технологийг ашиглах” сэдэвт сургалтыг орон нутагт нь зохион байгуулав.

Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Арьс шир” хөтөлбөрт нэмэлт оруулах тухай төсөл, “Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутагт үйл ажиллагаа явуулах журам”-ын төслийг тус тус боловсруулав.

ОХУ-аас импортоор оруулж ирсэн хүнсний 6134.0 тн улаанбуудайг аж ахуйн нэгжүүдийн гурилын үйлдвэрүүдэд борлуулаад байна.

Үрийн будаа, хор гербицид, үр бордооны захиалгыг аж ахуйн нэгжүүд, аймгуудын ХХААГ-аас авч нэгтгэн хуваарийг батлахад бэлэн болгов.

Дунд оврын төмсний иж бүрдэл болон жижиг оврын 16 тракторыг аж ахуйн нэгж, иргэдэд гэрээгээр олгох ажлыг зохион байгуулав.

“Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн, худалдааг “Мишээл Экспо” төвд зохион байгуулж, 150 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулан 400.0 сая гаруй төгрөгийн борлуулалт хийжээ.

НҮБ-ын ХХААБ-ын Суурин төлөөлөгчийн Монгол Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулж “Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийг хандивлагчдад танилцуулах, хуралдааныг зохион байгуулах болон цаашид хамтран ажиллах талаар харилцан тохиролцов.

**Зарим аймагт мал өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Баян-Өлгий, Ховд, Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Хэнтий аймгийн малчдад улсын нөөцөөс 5.0 мянган тонн өвс, 4.0 мянган тонн тэжээлийг хөнгөлөлттэй үнээр олголоо.**

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны харъяа Отрын малыг эрсдэлээс хамгаалах тэжээлийн нөөц бүрдүүлэх үүрэгтэй Төв аймгийн Баянчандмань,

Жаргалант сумдад ажилладаг бага оврын 2 тэжээлийн цехийн үйлдвэрлэлийн жигд, хэвийн ажиллагааг хангаж, нийт 100 тонн багсармал тэжээл үйлдвэрлэж, нөөцлөв.

Аймаг дундын отрын бүс нутагт 529 өрхийн 349.5 мянган мал отроор өвөлжиж байгаа бөгөөд малын зүй бус хорогдлоос сэргийлэх зорилгоор Завхан аймгийн Завханмандал, Ургамал, Дөрвөлжин сумын 60 өрхөд 8 тонн тэжээл зээлээр олгож, Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 10 тонн, Завхан аймгийн Завханмандал сум дахь Багахайрханы отрын бүс нутагт 17 тонн багсармал тэжээл хүргүүлэв. Аймаг дундын отрын бүс нутагт инженерийн хийцтэй 24, энгийн уурхайн 14 худаг ажиллуулж, усан хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

3 дугаар сарын 10-ны байдлаар отрын бүс нутгаас 166 өрхийн 114005 мал орон нутагтаа буцаж, 377 өрхийн 254982 мал хаваржиж байв.

Отрын бүсэд өвөлжсөн нийт 150 өрхийг хүн эмнэлгийн үзлэг, үйлчилгээнд хамруулж, 8000 малд ивомек тарилга хийж, 53 тонн багсармал тэжээл тээвэрлэн борлуулсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын удирдах ажилтны зөвлөлгөөнийг 2009 оны 2 дугаар сарын 12-13 ны өдрүүдэд зохион байгуулав. Уг зөвлөгөөний үеэр Мал эмнэлэг, үржлийн албаны удирдах ажилтны салбар зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд аймаг, нийслэлийн ХХААГ, Мал эмнэлгийн алба, Мал үржлийн алба болон бусад холбогдох байгууллагын удирдах ажилтнууд оролцлоо.

“Алтан төлийн эзэн”, салбарын хулгана жилийн “Есөн алдартан”-г шалгаруулан, шагналыг орон нутагт хүргэх, гардуулах ажлыг зохион байгуулав.

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч” шалгаруулах тухай саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, 34 дүгээр тогтоолоор шийдвэрлэв.

**Монгол Улс дотоодын махны хэрэгцээгээ 100 хувь хангаж байгаа. 2009 оны тариалалтын хэмжээ өмнөх оноос эрс нэмэгдэж байгаа тул хаврын тариалалтын бэлтгэлийг хангаж байна.**

### **Батлан хамгаалах чиглэлээр**

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтыг "Хямралт байдлын үед цэргийн хүчийг ашиглах онол, эрх зүйн зарим асуудал" сэдвээр зохион байгууллаа.

2009 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаарыг батлах тухай, Мөнгөн төлбөрийн дээд хэмжээ тогтоох тухай, 2009 онд татах хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдын тоо, цэрэг халалт, таталтын хугацаа тогтоох, 2010 онд Зэвсэгт хүчний 120 дугаар ангитай дайчилгаатай хээрийн сургууль явуулах тухай асуудлуудыг шийдвэрлэлээ.

Дүүргүүдийн Засаг дарга нар болон дайчилгааны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан Батлан хамгаалах бодлого, дайчилгааны төлөвлөлтийн асуудлаар сургалт зохион байгуулав.

2008-2009 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 014, 016, 119, 120, 326 дугаар ангиудтай “Зэвсэгт хүчний анги, салбаруудыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлж, тусгай чиглэлд маневрын хориглох байлдааныг явуулах үеийн

Ерөнхий зориулалтын цэргийн анги, салбаруудын харилцан ажиллагаа” сэдэвт команд штабын хээрийн сургуулийг удирдан явуулсан байна.

“Монгол Улсын агаарын орон зайн хяналт, удирдлагын автоматжуулсан систем КМ-2008” төслийн хүрээнд Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн Удирдлагын төв байр, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн хорооны удирдлагын байр, 323 дугаар салбарын удирдлагын байруудыг нэгдсэн сүлжээнд холбоход шаардлагатай тоног төхөөрөмж, пульта системийг суурилуулан сургалт зохион байгуулав.

Засгийн газар хоорондын цэрэг-техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд буцалтгүй тусламжаар авах зэвсэг, техникийн талаарх саналыг ОХУ-ын Батлан хамгаалах яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна.

Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний цэргийн багийн хамтарсан “Дархан-1” энхийг сахиулах ажиллагааны сургалт, дадлагын хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчинд буцалтгүй тусламжаар нийлүүлсэн зэвсэглэл, техник, сэлбэг, хэрэгслийг данс бүртгэлд авч, зарцуулалтад нь хяналт тавин ажиллаж байна. Мөн “Дархан-2” энхийг сахиулах ажиллагааны сургалт, дадлагад оролцох ангиудын авто, хуягт техникийн сэлбэг, хэрэгслийн тооцоог нэгтгэн гаргалаа.

Монгол Улс, АНУ-ын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны 2009 оны төлөвлөгөөний дагуу АНУ-ын Аляскийн үндэсний гвардитай хамтран “Энхийг дэмжих ажиллагаанд хууль, дэг журам сахиулах нь” сэдэвт мэргэжилтнүүдийн туршлага солилцох семинарыг зохион байгуулж, Зэвсэгт хүчний 8 анги, байгууллага, ЦЕГ, Дотоодын цэргийн штабын 35 цэргийн алба хаагчийг оролцууллаа.

Манай улсын Зэвсэгт хүчний цэргийн туршуулын бүлэг БНПУ, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний багтай хамтран Афганистан Улсад явагдаж буй НАТО-гийн цэргийн ажиллагаанд оролцох боломжийг судлах томилолтоор ажиллаад ирлээ.

Монгол-Солонгосын Батлан хамгаалах яам хоорондын дунд хэмжээний зөвлөлдөх уулзалтыг БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулж хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд 2009 онд хэрэгжүүлэх арга хэмжээг тодотгон, тус улсаас буцалтгүй тусламжаар цэргийн холбооны хэрэгсэл авах гэрээг үзэглэв.

Монгол Хятадын хамтарсан энхийг сахиулах хээрийн сургууль явуулахад бэлтгэх ажлын хэсгийн төлөвлөлтийн бага хурлыг БНХАУ-ын Бээжин хотноо амжилттай зохион байгуулав.

БНЭУ-аас Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа Г.Жэйшанкар манай улсад, Батлан хамгаалахын сайд Л.Болд БНЭУ-д албан ёсны айлчлал хийлээ. Монгол, Энэтхэгийн цэргийн тусгай хүчний хамтарсан “Нүүдэлчин заан” хээрийн сургуулийг уламжлал болгон зохион байгуулах, хоёр орны батлан хамгаалах салбарын дээд хэмжээний уулзалт, төлөөлөгч солилцох, ажлын уулзалт хийх, цэргийн сургалт болон цэргийн хамтарсан сургуулиуд, боловсон хүчнийг бэлтгэх зэрэг салбарт хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх талаар ярилцлаа.

### **Гадаад харилцааны чиглэлээр**

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн Давосын “Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт”-д оролцох бэлтгэл ажил болон Бүгд Найрамдах Сингапур Улс, Бруней Улсад хийх, Ерөнхий сайдын ХБНГУ, Европын Холбоо, Франц, Люксембургийн Их Гүнт Улсад хийх айлчиллаа.**

**Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр ОХУ-аас газар тариалангийн салбарт зориулж зээлэх 300 сая ам. долларын хэлэлцээр, Монгол Улсын БСШУЯ, ОХУ-ын Соёлын яамны хооронд 2009-2011 онд соёлын салбарт хамтран ажиллах хөтөлбөрт гарын үсэг зурав.**

Ерөнхий сайд С.Баярын Франц, Люксембург, ХБНГУ болон Европын Холбоонд хийх айлчлалын бэлтгэлийг хангаж ажиллалаа.

Ерөнхий сайд С.Баяр ОХУ-ын Эрхүү мужид ажлын айлчлал хийж ОХУ-ын Хөдөө аж Ахуйн сайд, ОХУ-ын ерөнхийлөгчийн тусгай бие төлөөлөгч, Монгол, Оросын ЗГХК-ын Оросын талын дарга А.В. Гордеев, Оросын төмөр зам НХН-ийн ерөнхийлөгч В.И. Якунин, Росатом корпорацийн ерөнхий захирал С.В. Кириенко нартай уулзаж яриа хэлэлцээ хийв.

Гадаад харилцааны сайд С.Батболд, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровын урилгаар ОХУ-д албан ёсны айлчлал хийж хэлэлцээ хийв. Хэлэлцээний үеэр сайд С.Батболд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяраас ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевийг 2009 оны 8 дугаар сард тэмдэглэх Халх голын байлдааны хамтын ялалтын 70 жилийн ойн үеэр төрийн айлчлал хийж, баярын ажиллагаанд оролцохыг урьсан албан ёсны урилгыг ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровт гардуулав.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын Худалдааг либералчлах Ажлын хэсгийн VIII хуралдааныг Москва хотноо хуралдууллаа.

ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын Ерөнхийлөгчийн айлчлалыг зохион байгуулав.

Монгол-Оросын ЗГХК-ын 13 дугаар хуралдаан, Монгол Улс, БНХАУ-ын хилийн боомтын хамтарсан механизмын анхдугаар зөвлөлгөөнд оролцож протокол байгуулав.

Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод, Баянхошуу-Өвдөг боомтыг 2009 онд бүтэн жилийн турш ажиллуулахаар тохиролцсон байна.

Гадаад харилцааны сайд С.Батболд, Япон Улсын талаас Элчин сайд Я.Ичихаши, JICA-ийн суурин төлөөлөгч Ю.Ишида нар Тус улсаас Монгол Улсад олгох буцалтгүй тусламжийн хүрээнд Төслийн бус буцалтгүй тусламж, “Хархорины музей барих” төсөл, “Дархан хотын усан хангамжийг сайжруулах” төсөл, “Бага, дунд боловсролын сургуулийн барилга, өргөтгөл барих” төслийн 4 дэх үе шат, “Улаанбаатар хотын төмөр замын гүүрэн гарц барих” төслийн нарийвчилсан зураг төсөл зэрэг нийт 6 төслийн баримт бичигт гарын үсэг зурав.

Европын Комиссоос Монгол Улсын Засгийн газраас гаргасан хүсэлтийн дагуу “Сайн засаглал, тогтвортой хөгжил”-ийн болзол бүхий хөнгөлөлт буюу 7200 нэрийн барааг импортын “0” татвартайгаар Европын Холбооны гишүүн 27 оронд экспортлох “GSP+” хөнгөлөлтийг 2009-2011 онуудад үргэлжлүүлэн олгохоор шийдвэрлэсэн байна.

Японы Ерөнхий сайд Таро Асо, БНСУ-ын Ерөнхийлөгч Ли Мён Бак болон БНАСАУ-ын удирдагч Ким Жон Ир нарыг Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх ЗХА-ийн орнуудын дээд хэмжээний уулзалтад урьсан Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгыг холбогдох талуудад гардуулав.

**Бүгд Найрамдах Солонгос Улстай “Иргэд зорчих нөхцөлийг харилцан хөнгөвчлөх” тухай ноот бичиг солилцлоо.**

“Монгол Улсын экспортыг хөгжүүлэх үндэсний стратеги” боловсруулах ажлын хүрээнд Олон улсын худалдааны төв (International Trade Centre)-тэй видео конференц зохион байгуулав.

ГХЯ, НҮБ-ын ХХБ болон Женев дэх Байнгын төлөөлөгчийн газартай хамтран “Худалдааг хөнгөвчлөх” сэдэвт семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

“Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенци”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-аар соёрхон батлуулав.

### **Хууль зүйн чиглэлээр**

**”Хууль тогтоомжийг 2009-2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэж, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аар батлууллаа.**

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуугийн санаачилсан Монгол Улсын Эрүүгийн /төрөлжсөн/ хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Р.Рашийн санаачилсан Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Г.Батхүүгийн санаачилсан Нийлэг уутны хэрэглээг хязгаарлах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай, НӨАТ-аас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Д.Арвины санаачилсан Өршөөл үзүүлэх тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдэд Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг бэлтгэв

Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг хянаж, бүртгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбогдуулан бүх яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарыг оролцуулсан уулзалт-ярилцлагыг Дэлхийн банкны Захиргааны шийдвэрийг стандартчилах төсөлтэй хамтран зохион байгууллаа.

Эрх зүйн актыг бүртгэх, эрх зүйн актын ангилагчийг ашиглаж системчилсэн картын сан, хяналтын хувийг хөтлөх аргачилсан зөвлөмжийг батлан аймгийн Засаг даргын Тамгын газруудын Хууль зүйн хэлтэс болон УИХ-ын Тамгын газар, УДШ, ҮХЦ, ХЗҮХ зэрэг байгууллагуудад тус тус хүргүүлээд байна.

“Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын гэрээ”, “Зарим цогцос оршуулах журам”-ыг батлав.

Тайлангийн хугацаанд төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтийг үндэслэн албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд орох 1151, орох, гарах 37, олон удаагийн 114, нийт 1302 гадаадын иргэнд виз олгох зөвшөөрлийг өгч, гарах, орох 468, гарах 282, олон удаагийн 402 виз олгосон.

Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болон визийн хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан гадаадын 16 орны 100

иргэнд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу 16.4 сая төгрөгийн мөнгөн торгууль ногдуулсан байна.

Гадаадын орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 12 байгууллага, аж ахуйн нэгжид 7.5 сая төгрөгийн мөнгөн торгууль ногдуулан улсын орлогод оруулсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар